



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Халзан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/121/НА-СТА-ТШЗ

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт 2022 он</p> | <p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Аудитор: Утас: 70512127 Цахим хаяг: barchidgunseno@audit.gov.mn</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|----|
| 1. Аудитын санал дүгнэлт | 2 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 4 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 6 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 7 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан | 8 |
| 3. Аудитын тайлан | 8 |
| 3.1 Ерөнхий зүйл | 9 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 9 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 9 |
| 3.4 Материаллаг байдал | 10 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 10 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 11 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 11 |
| 3.8 Аудитын гол асуудал | 12 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 12 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 12 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 13 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 13 |
| 4. Аудитын илрүүлэлт | 13 |
| 4.1 Зөвлөмж | 13 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 14 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

дод. од. дс № 39
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Л.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халзан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халзан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-----------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 41,711,790.00 | 44,822,690.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 41,711,790.00 | 44,822,690.00 |
| 351 | Түүхий эд материал | 265,000.00 | 786,500.00 |
| 35130 | Эм боох материал | 265,000.00 | 786,500.00 |
| 354 | Хангамжийн материал | 41,446,790.00 | 44,036,190.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 664,980.00 | 1,738,880.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 34,662,290.00 | 36,753,090.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 592,450.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,119,520.00 | 4,951,770.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 131,921,522.44 | 1,163,305,856.12 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 131,921,522.44 | 1,163,305,856.12 |
| 392 | Биет хөрөнгө | 130,409,522.44 | 1,161,793,856.12 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 97,613,692.95 | 1,156,021,589.95 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -13,316,720.16 | -29,805,419.88 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 49,111,530.00 | 49,461,030.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -24,312,811.40 | -31,857,462.79 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 31,001,204.50 | 31,001,204.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,044,042.73 | -15,407,754.94 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,100,000.00 | 5,100,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -5,100,000.00 | -5,100,000.00 |
| 39217 | Ном | 2,356,669.28 | 2,380,669.28 |
| 393 | Биет бус хөрөнгө | 1,512,000.00 | 1,512,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,512,000.00 | 1,512,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 173,633,312.44 | 1,208,128,546.12 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 173,633,312.44 | 1,208,128,546.12 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 173,633,312.44 | 1,208,128,546.12 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 60,747,770.00 | 60,747,770.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 60,747,770.00 | 60,747,770.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 44,667,489.53 | 1,079,162,723.21 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 44,667,489.53 | 44,667,489.53 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,034,495,233.68 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 68,218,052.91 | 68,218,052.91 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 173,633,312.44 | 1,208,128,546.12 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 288,933,574.50 | 1,325,866,897.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 32,729,004.50 | 1,059,981,497.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 32,729,004.50 | 1,059,981,497.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 32,729,004.50 | 1,059,981,497.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 32,729,004.50 | 1,059,981,497.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 29,261,370.00 | 39,217,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 226,943,200.00 | 226,668,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,849,570.00 | 200,000.00 |

Халзан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,020,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 200,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,829,570.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 24,411,800.00 | 39,017,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 24,411,800.00 | 39,017,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 264,568,901.21 | 291,371,663.32 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 264,568,901.21 | 291,371,663.32 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 256,522,438.93 | 289,402,759.61 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 175,892,128.72 | 178,122,913.43 |
| 210101 | Үндсэн цалин | 111,310,435.83 | 120,074,884.02 |
| 210102 | Нэмэгдэл | 42,865,512.06 | 41,120,423.60 |
| 210104 | Урамшуулал | 21,716,180.83 | 16,927,605.81 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,340,900.00 | 29,021,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,191,800.00 | 22,337,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,787,300.00 | 1,670,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,429,800.00 | 1,336,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 357,500.00 | 334,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,574,500.00 | 3,341,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,407,603.00 | 34,303,724.61 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,008,423.00 | 1,433,735.61 |
| 210302 | Түлш, халаалт | 17,254,200.00 | 32,178,189.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,144,980.00 | 691,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,392,350.00 | 1,929,630.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 229,130.00 | 319,240.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 553,650.00 | 546,050.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 57,530.00 | 228,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 552,040.00 | 836,340.00 |
| 2105 | Нормативт зардал | 17,554,216.50 | 7,814,706.25 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,700,520.00 | 98,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,704,496.50 | 7,716,706.25 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 149,200.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 122,500.00 | 4,810,647.00 |
| 210604 | Урсгал засвар | 122,500.00 | 4,810,647.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 70,000.00 | 42,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 70,000.00 | 42,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,922,203.00 | 439,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,922,203.00 | 439,300.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,820,537.71 | 32,918,738.32 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,656,766.50 | 4,567,750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,736,610.00 | 953,925.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 13,427,161.21 | 27,397,063.32 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,046,462.28 | 1,968,903.71 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 8,046,462.28 | 1,968,903.71 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,046,462.28 | 1,968,903.71 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 24,364,673.29 | 1,034,495,233.68 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 9,881,677.52 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 9,881,677.52 | 00.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -9,881,677.52 | 00.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 14,482,995.77 | 1,034,495,233.68 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|-------|--|
| C01 | 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 60,747,770.00 | 68,218,052.91 | 44,667,489.53 | 00.00 | 173,633,312.44 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 60,747,770.00 | 68,218,052.91 | 44,667,489.53 | 00.00 | 173,633,312.44 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 60,747,770.00 | 68,218,052.91 | 44,667,489.53 | 00.00 | 173,633,312.44 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,034,495,233.68 | 00.00 | 1,034,495,233.68 |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 60,747,770.00 | 68,218,052.91 | 1,079,162,723.21 | 00.00 | 1,208,128,546.12 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 256,204,570.00 | 265,885,400.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 256,204,570.00 | 265,885,400.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 226,943,200.00 | 226,668,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,849,570.00 | 200,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,020,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 200,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,829,570.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 24,411,800.00 | 39,017,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 24,411,800.00 | 39,017,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 255,774,970.00 | 265,511,900.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 255,774,970.00 | 265,511,900.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 247,728,507.72 | 263,542,996.29 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 175,892,128.72 | 178,122,913.43 |
| 210101 | Үндсэн цалин | 111,310,435.83 | 120,074,884.02 |
| 210102 | Нэмэгдэл | 42,865,512.06 | 41,120,423.60 |
| 210104 | Урамшуулал | 21,716,180.83 | 16,927,605.81 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,340,900.00 | 29,021,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,191,800.00 | 22,337,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,787,300.00 | 1,670,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,429,800.00 | 1,336,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 357,500.00 | 334,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,574,500.00 | 3,341,700.00 |

Халзан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|---------------------------|---------------------------|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,495,603.00 | 34,300,724.61 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,096,423.00 | 1,433,735.61 |
| 210302 | Түлш, халаалт | 17,254,200.00 | 32,178,189.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,144,980.00 | 688,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,832,730.00 | 1,722,937.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 271,200.00 | 420,540.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 553,650.00 | 546,050.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 57,530.00 | 228,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,950,350.00 | 528,347.00 |
| 2105 | Нормативт зардал | 16,658,377.00 | 9,224,956.25 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,142,130.00 | 69,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,024,547.00 | 8,309,156.25 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 491,700.00 | 845,900.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,499,800.00 | 3,649,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,499,800.00 | 3,649,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 70,000.00 | 42,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 70,000.00 | 42,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,948,193.00 | 459,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,948,193.00 | 459,300.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,990,776.00 | 6,999,665.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,746,996.00 | 5,692,040.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,243,780.00 | 1,307,625.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8,046,462.28 | 1,968,903.71 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 8,046,462.28 | 1,968,903.71 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,046,462.28 | 1,968,903.71 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>429,600.00</u> | <u>373,500.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 429,600.00 | 373,500.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 429,600.00 | 373,500.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 429,600.00 | 373,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 429,600.00 | 373,500.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-429,600.00</u> | <u>-373,500.00</u> |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 265,685,400.00 | 263,716,496.29 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 265,685,400.00 | 263,716,496.29 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 265,685,400.00 | 263,716,496.29 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 178,869,200.00 | 178,122,913.43 |
| 210101 | Үндсэн цалин | 138,124,500.00 | 120,074,884.02 |
| 210102 | Нэмэгдэл | 26,847,400.00 | 41,120,423.60 |
| 210104 | Урамшуулал | 13,897,300.00 | 16,927,605.81 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,021,100.00 | 29,021,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,337,800.00 | 22,337,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,670,900.00 | 1,670,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,336,600.00 | 1,336,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 334,100.00 | 334,100.00 |

Халзан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,341,700.00 | 3,341,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 35,017,000.00 | 34,300,724.61 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,070,300.00 | 1,433,735.61 |
| 210302 | Түлш, халаалт | 30,714,400.00 | 32,178,189.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,232,300.00 | 688,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,550,900.00 | 1,546,937.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 497,700.00 | 420,540.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 550,000.00 | 546,050.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 256,000.00 | 228,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 45,600.00 | 24,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 201,600.00 | 328,347.00 |
| 2105 | Нормативт зардал | 9,650,200.00 | 9,224,956.25 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 69,900.00 | 69,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,728,800.00 | 8,309,156.25 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 851,500.00 | 845,900.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,000,000.00 | 3,998,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 3,998,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 117,000.00 | 42,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 117,000.00 | 42,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 459,300.00 | 459,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 459,300.00 | 459,300.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7000700.00 | 6999665.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,693,000.00 | 5,692,040.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,307,700.00 | 1,307,625.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 265,685,400.00 | 263,716,496.29 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 226,668,400.00 | 225,416,871.68 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 226,668,400.00 | 225,416,871.68 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 39,017,000.00 | 38,299,624.61 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 39,017,000.00 | 38,299,624.61 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 16.00 | 16.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 09.00 | 09.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|--|-------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 200,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 200,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 200,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 200,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 200000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 200,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200,000.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халзан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс, тээвэр шатахуун, үндсэн хөрөнгө, түлш халаалтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Барчидгүнсэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Халзан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Халзан сумын хүүхдийн цэцэрлэг нь “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 274.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Халзан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,034.5 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|-------------------|--------------------|----------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 0.00 | 0.00 |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 41.7 | 44.8 | 3.1 |
| Үндсэн хөрөнгө | 131.9 | 1,163.3 | 1,031.4 |
| Нийт хөрөнгө | 173.6 | 1,208.1 | 1,034.5 |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 173.6 | 1,208.1 | 1,034.4 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 173.6 | 1,208.1 | 1,034.5 |

Бараа материалын дансны үлдэгдэл 44.8 сая төгрөг болж 3.1 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал 0.5 сая, бичиг хэргийн материал 1.1 сая, аж ахуйн материал нийт 2.1 сая, хүнсний материал 0.5 сая, нийт 4.2 сая төгрөгөөр үлдэгдэл өссөн, бусад хангамжийн материал 1.2 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,245.4 сая төгрөг болж 1,058.8 сая төгрөгөөр өссөн нь аймгийн ИТХ-ын 2021 оны 39 дүгээр тогтоолоор 1,058.4 сая төгрөгийн 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга ашиглалтад орсон, элэгдлийн зардлаар хөрөнгө өссөн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,208.1 сая төгрөг болж 1,034.4 сая төгрөгөөр өссөн байна.

Халзан сумын хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,036.8 сая төгрөгөөр буюу 458.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Тодруулбал үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1036.9 сая төгрөгөөр өссөн, үр дүнгийн тайлангийн орлого өсөхөд голлон нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 26.8 сая төгрөгөөр буюу 10.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт халаалт дулааны зардал шинэ байр ашиглалтад орсонтой холбоотой өссөн, эм бэлдмэл, хичээл үйлдвэрлэл, хоол хүнс зэрэг зардлууд буурсан байна. Энэ нь короновирус цар тахлын хүрээнд цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосон, засгийн газрын 2021 оны 43 дүгээр тогтоолын дагуу төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлсэнтэй нь холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 621.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 621.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 127.6 сая төгрөгөөр бууруулж 265.6 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2021 онд короновирус гарсантай холбогдуулан улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулан хоолны зардлыг бууруулж төсөвт тодотгол хийсэн нь нөлөөлсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 265.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 263.7 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 1.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нийт зардлын 226.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 39.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 0.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 0.2 сая төгрөгийг зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Тайлант онд Халзан сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.6 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Халзан сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 153 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцорч 1 мэдээлэл, хугацаа болоогүй 4 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй бөгөөд акт албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|-----------------|---------------------|-----|---------|-----|-------|-----|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | - | - | - | - | - | - | - |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | - |
| Зөвлөмж | - | - | - | - | - | - | - |
| Нийт дүн | - | - | - | - | - | - | - |

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Халзан сумын хүүхдийн цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитын явцад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг үүсээгүй .

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 64 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | | |
|-----|-------------------------------------|----------------------|-----|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| 1 | Халзан сумын хүүхдийн цэцэрлэг | 1 | - | - | - | - | - | - | - | - | 1 | - |